



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 303

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2, 6.3.4, 6.4.1, 6.4.3, 6.4.4, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хэнтий аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, Мэргэжлийн хяналтын Улсын байцаагчийн 2020 оны 22-07-022/42 дугаар дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй болох нь тогтоогдсон, 4 нэрийн нийт 4,077,200.00 (дөрвөн сая далан долоон мянга хоёр зуун) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Т.Жамбалцэрэн, Хэнтий аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Ж.Энх-Амгалан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Үл хөдлөх хөрөнгийг акталж, чөлөөлөгдсөн Хэнтий аймгийн Хэрлэн сумын 1 дүгээр багт байрлах газар эзэмших эрхийн гэрчилгээний 00002134, нэгж талбарын 2311034338 дугаар бүхий 984 м.кв газрыг байгууллагын эзэмшилд Төрийн байгууллагын зориулалтаар ашиглах;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайландаа тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4 Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан тайлагнах.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

3.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫНААЛВАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНГЭРЭЛ

300400

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2020 оны 05 дүгээр сарын 19-ны өдрийн
309 дугаар тогтоолын хавсралт

ХЭНТИЙ АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГОД БҮРТГЭЛТЭЙ,
АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГ СААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл
					(төгрөг)
1	Хашаа	1989.01.01	ш	1	312,000.00
2	Ногооны зоорь	2014.12.11	ш	1	1,442,000.00
3	Ёнкос	2014.12.11	ш	1	1,500,000.00
4	Дүнзэн склад	1989.01.01	ш	1	823,200.00
Нийт дүн					4,077,200.00 (дөрвөн сая далан долоон мянга хоёр зуун)